



# БУЛГАН СУМЫН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл  
дараах хаягаар харилцана уу:**

Баян-Өлгий аймгийн  
Аудитын газар

Дарга, Тэргүүлэх аудитор  
М.Хуанган  
Утас: 70422954  
Цахим хаяг:

Аудитын менежер:  
Х.Женисбек  
Утас: 70422930  
Цахим хаяг:

Ахлах аудитор: М.Айнур  
Утас: 94159291  
Цахим хаяг:  
ainurmarkhava@yahoo.com

**Хаяг:** Баян-Өлгий аймгийн  
Аудитын газар

**Байршил:** Өлгий сум, 5-р баг,  
Аймгийн ЗДТГазрын байр, 1-р  
давхар  
**Цахим хуудас:** [www.audit.mn](http://www.audit.mn)

**2018 оны 3 дугаар сар**

## Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

## АГУУЛГА

---

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Зөвлөмж
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

### **Нэг. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:**

Төсвийн тухай хуулийн 8.9.3, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2-т заасан аймаг дах Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд /БӨА-2018/10/СТА-ТТЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 3 дугаар сарын 17-наас 3 дугаар сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөж, ахлах аудитор М.Айнур хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн тайланг хуулийн хугацаанд 2018 оны 3 дугаар сарын 05-нд Аймгийн Аудитын газарт ирүүлсэн.

Аймаг дах Төрийн аудитын газар аудитыг 2018 оны 3 дугаар сарын 23-наас 3 дугаар сарын 28-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 3 дугаар сарын 28-нд Булган сумын Засаг дарга гардуулна.

### **Хоёр. Байгууллагын хууль, эрх зүйн орчин:**

Булган сумын Засаг дарга нь Монгол улсын Төсвийн тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төрийн албаны

тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

### **Гурав. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:**

“Төрийн албаны болон холбогдох хууль тогтоомжуудыг ажилдаа мөрдлөг болгож, авлига, ашиг сонирхлын зөрчилд автахгүй. Үйл ажиллагаандаа төрийн албаны стандартыг дагаж мөрдөн, дотоод ажлыг сайжруулна” гэж төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн удирдлага дор төсвийн шууд захирагчийг харьяалах эрх бүхий төсвийн төвлөрүүлэн захирагчтай байж болно”, 15.4-д “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 15.4.1-д “төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-д заасны дагуу Булган сумын Засаг дарга нь Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Булган сумын Засаг даргын 2017 оны төсвийг аймгийн ТЕЗ-ийн орон нутгийн төсөв, тусгай зориулалтын шилжүүлэгийн төсвийн багцаас аймгийн төрийн сангаас олгосон байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Булган сумын Засаг дарга Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

### **Дөрөв. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:**

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын

бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 40-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад тус сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг батлаагүй боловч Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан төсвийн байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх заавар аргачлал, нягтлан бодох бүртгэлийн бодлого, арга зүйг, Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ыг мөрдөж ажилласан байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг “Санхүүгийн тооцоолох төв” ХХК-ны “Прибаланс” санхүүгийн програмаар боловсруулан төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

#### **Тав. Дотоод хяналт:**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед 33 буюу “их” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн байна.

#### **Зургаа. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:**

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу аймгийн ТЭЗ-ийн орон нутгийн төсөв, тусгай зориулалтын шилжүүлэгийн төсвийн багцаас аймаг, сумын төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн

гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

## 6.1 Орлого, татаас санхүүжилтийн талаар

### 6.1.1 Улсын төсвийн санхүүжилт

Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд тусгай зориулалтын шилжүүлгээр нийтдээ 2640,3 сая төгрөгийн санхүүжилт, 25,9 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийг хүлээн авсан байна.

### 6.1.2 Орон нутгийн төсвийн санхүүжилт

Орон нутгийн захиргааны байгууллагууд аймгийн төсвөөс 322,4 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг хүлээн авч, орон нутгийн татварын орлогоос 130,8 сая төгрөгийн, аймгийн ОНХ-ийн сангаас 78,5 сая төгрөгийн орлогын эх үүсвэр бүрдүүлэн санхүүжүүлсэн байна. Үйл ажиллагааны орлогоос 0.9 сая төгрөгийн орлогыг хүлээн авчээ.

### 6.1.3 Өөрийн орлого

Булган сумын төсөвт байгууллагуудад үндсэн үйл ажиллагааны орлогоос 1,3 сая төгрөгийн орлого оруулах төлөвлөгөө өгөгдсөнөөс 0,9 сая төгрөгийн орлого оруулсан байна. Мөнгөн гүйлгээний тайлангаар СХСангийн эргэн төлөлтөөс орсон 38,4 сая төгрөгийн, ЭЭС-аас орсон 5,4 сая төгрөгийн орлогыг өөрийн үйл ажиллагааны орлогоор тайлагнасан байна.

### 6.1.4 Татварын орлого

Аймгийн ИТХ-аас Булган сумын 2017 оны орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөг 63,9 сая төгрөгөөр баталжээ. Орлогын 25,8 хувийг ХАОАТатвараас, 74,2 хувийг бусад татвараас, татварын бус орлогоос бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №01		/сая төгрөг/			
	ᠶᠡᠨᠠᠭᠤᠨ ᠶᠡᠨᠠᠭᠤᠨ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	<b>А.Урсгал орлого</b>	<b>63,9</b>	<b>201,5</b>	<b>137,5</b>	<b>315</b>
2	<b>Татварын орлого</b>	63,9	200,7	136,8	314
3	<b>ХАОАТатвар</b>	16,5	35,8	19,3	216,9
4	<b>Өмчийн татвар</b>	0.00	0.00		0.0
5	<b>Бусад татвар</b>	47,4	164,9	117,5	347,7
6	<b>II.Татварын бус орлого</b>	0.0	0,2	0,2	-
7	<b>Б.ХӨРӨНГИЙН ОРЛОГО</b>	0,05	0,6	0,55	1200

Гүйцэтгэлээр Орон нутгийн орлогод нийтдээ 201,5 сая төгрөг төвлөрүүлж төлөвлөгөөг 137,5 сая төгрөгөөр буюу 3,1 дахин давуулан биелүүлсэн байна. Нийт орлогын 17,8 хувийг ХАОАТатварын, 81,8 хувийг бусад татварын, 0,4 хувийг татварын бус орлого, хөрөнгийн орлогоос бүрдүүлжээ.

Орлогын нэр төрлөөр авч үзэхэд ХАОАТатвар 19,3 сая төгрөгөөр буюу 217,1 хувиар давж, татварын бус орлого 117,5 сая төгрөг буюу 347,7 хувиар давж биелэгджээ.

Тасарсан орлого байхгүй байна.

Орон нутгийн орлогын 910 тоот дансны оны эхэнд үлдэгдэл 104,1 сая төгрөгийн үлдэгдэлтэй, 201,5 сая төгрөгийн татварын орлого оруулж, 132,8 сая төгрөгийг зарцуулж, оны эцэст 174,8 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

### **6.1.5 Бусад**

Тайланд онд ОНХСангийн санхүүжилтэнд 52,1 сая төгрөгийн санхүүжилт авч, Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөс 38,4 сая төгрөгийн, Эргэлтийн эмийн сангаас 5,4 сая төгрөгийн орлого оруулсан байна. Урьд жилд ЭМТ-ийн нэмэлт данснаас төвлөрүүлсэн 0,7 сая төгрөгийн үлдэгдэл дээр 3,0 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төвлөрүүлсэн орлогын дүн 3,7 сая төгрөг болсон байна.

## **6.2 Төсвийн зарлага санхүүжилтийн талаар:**

### **6.2.1 Төсвийн гүйцэтгэлийн талаар**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Булган сумын ТТЗ-ийн өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой төсөвт байгууллагуудын хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2017 оны урсгал зардалд нийтдээ 3228,0 сая төгрөгийн төсөв батлагдсаны 2641,0 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээр, 481,8 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 92,4 сая төгрөгийг ОНХСангийн хөрөнгөөр, 2,0 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоор, урьд оны үлдэгдлээс 10,8 сая төгрөгийг санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээр 2640,3 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 479,8 сая төгрөгийн, аймгийн ОНХСангаас орлогын шилжүүлэгээр 86,5 сая төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны 3,8 сая төгрөгийн орлого оруулж, бүгд 3210,4 сая төгрөгийн зарлага санхүүжилтээр ажиллаж, батлагдсан

төсвөөс нийт дүнгээр 17,6 сая төгрөгөөр бага зарлага гаргажээ. Энэ нь БОХ санд төлөвлөсөн 10,8 сая төгрөгийг зарцуулаагүй, ОНХ сангийн 5,9 сая төгрөгийг зарцуулагдаагүй үлдэгдэлтэй гарсан, сумын ИТХ-аас 2,0 сая төгрөгийг үлдэгдлийг төвлөрүүлсэнтэй холбоотой.

Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

Хүснэгт №02		/ сая төгрөгөөр/			
№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	3228,0	3210,3	99,5 %	-17,6
1.1	Урсгал зардал	3135,6	3123,9	99,6 %	-11,7
1.2	Хөрөнгийн зардал	92,4	86,5	93,6%	-5,9
2	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	3228,0	3210,3	99,5 %	-17,6
2.1	Улсын төсвөөс санхүүжих /Тусгай зориулалтын шилжүүлэг/	2641,0	2640,3	99,9 %	-0,7
2.2	Орон нутгийн төсвөөс	481,8	479,8	99,6 %	-2,0
2.3	Орон нутгийн хөгжлийн сангаас	92,4	86,5	93,6%	5,9
2.4	Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос	0,7	2,9	414,2%	-2,2
2.5	Урьд оны үлдэгдлээс	10,8	0	-	10,8

Төсвийн гүйцэтгэлийг зардлын зүйл ангиар авч үзвэл: Цалин хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ-ийн зардал, нормативт зардал, томилолт зочны зардлыг төсөвтөө багтаан зарцуулж, хангамж бараа материалын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал, бараа үйлчилгээний бусад зардал, урсгал шилжүүлгийн зардал, хөрөнгийн зардлыг 1,5-5,9 сая төгрөгөөр хэмнэж, эд хогшил урсгал завсарын зардлыг 0,6 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна.

Хүснэгт №03		/сая төгрөгөөр/			
Үзүүлэлт	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	хувиар	
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3228,0</b>	<b>3210,3</b>	<b>17,6</b>	<b>99,5 %</b>	
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	3135,6	3123,9	11,7	99,6 %	
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2798,9	2789,9	9,1	99,7%	
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1936,4	1936,4	-	100 %	
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	213,1	213,1	-	100.00	
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	190,6	190,4	-0,2	99,9	
Хангамж, бараа материалын зардал	82,4	80,9	-1,5	98,2	
Нормативт зардал	234,1	234,1	-	100.00	
Эд хогшил, урсгал засварын зардал	15,1	15,6	-	100.00	
Томилолт, зочны зардал	13,6	13,6	-	100.0	
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	48,4	45,8	-2,6	94,6	
Бараа үйлчилгээний бусад зардал	62,2	59,8	-2,4	96,1	
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	336,6	334,0	-2,4	99,2	
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>92,4</b>	<b>86,5</b>	<b>-5,9</b>	<b>93,6</b>	
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>3228,0</b>	<b>3210,3</b>	<b>-17,6</b>	<b>99,5 %</b>	
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	2641,0	2640,3	-0,7	99,9%	



Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	92,4	86,5	5,9	93,6
<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>481,8</b>	<b>479,8</b>	<b>-2,0</b>	<b>99,6</b>
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>0,7</b>	<b>2,9</b>	<b>-2,2</b>	<b>414,3</b>
Урьд оны үлдэгдлээс	10,8	0	-	-

*Төсвийн гүйцэтгэлийг байгууллага бүрээр харуулбал:*

Хүснэгт №04		/сая төгрөг/		
Төсөвт байгууллагуудын нэр	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	хувь
ИТХ	57,1	55,1	2,0	96,5
ЗДТГ	424,6	424,6	-0,01	100,0
Бүрэн дунд сургууль	1,321,7	1,321,6	0,09	100,0
Шүвтэрийн бага сургууль	290,1	289,9	0,01	99,9
Ёлтын бага сургууль	224,0	223,6	0,4	99,8
Хүүхдийн цэцэрлэг	230,7	230,7	0	100,0
Ёлтын хүүхдийн цэцэрлэг	93,0	92,9	0,06	99,9
ЭМтөв	426,9	426,9	0,0	100,0
Соёлын төв	55,8	55,4	0,4	99,2
ОНХ сан	92,4	86,5	5,9	93,6
СХсан	0,7	2,9	-2,2	421,4
БОХ сан	10,8	-	10,8	0,0
<b>дүн</b>	<b>3228,0</b>	<b>3210,3</b>	<b>17,6</b>	<b>99,5</b>

Төсөвт байгууллагууд төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулж, БОХ санд төлөвлөсөн 10,8 сая төгрөгийг зарцуулаагүй, ОНХ сангийн 5,9 сая төгрөгийг зарцуулагдаагүй үлдэгдэлтэй гарсан, сумын ИТХ 2,0 сая төгрөгийг зарцуулагдаагүй үлдэгдэлтэй гарсан байна.

### 6.2.2 Нэмэлт санхүүжилтийн зарцуулалт

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар нийтдээ 25,9 сая төгрөгийн орлого хүлээн авч урсгал зардалд зарцуулсан байна. Дээрх зардлыг санхүүжүүлсэн эх үүсвэрийг ангилал тус бүрээр нэмэлт төсвийн тайлангаар баримтжуулан баталгаажуулав.

### 6.2.3 Сангуудын зарцуулалт

Булган сумын ОНХСан нь оны эхэнд 40,3 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй ба тайлант онд 52,1 сая төгрөгийн санхүүжилт авч, 86,5 сая төгрөгийг сумын ИТХурлаас батлагдсан төсөл арга хэмжээнд зарцуулж, оны эцэст 5,9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Сум хөгжүүлэх сангийн харилцах данс оны эхэнд 13,1 сая төгрөгийн үлдэгдэлтэй, тайлант онд эргэн төлөлтөөс 38,4 сая төгрөгийн орлогыг оруулж, 2,9 сая төгрөгийг зарцуулж, 48,6 сая төгрөгийн үлдэгдэлтэй.СХСан нь жилийн эцэст 210,6 сая төгрөгийн зээлийн авлагатай байна.

Эргэлтийн эмийн сан оны эхэнд арилжааны банкин дахь харилцах дансандаа мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байсан ба тайлант онд 5,4 сая төгрөгийн орлого оруулж, 5,0 сая төгрөгийг зарцуулж оны эцэст 0,4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

### 6.3. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтийн талаарх тайлбар, тодруулга

#### 6.3.1 Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

Хүснэгт №05 /сая төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>158,2</b>	<b>233,5</b>	<b>75,3</b>
<b>311</b>	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>			
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>158,2</b>	<b>233,5</b>	<b>75,3</b>
<b>3121</b>	<b>Төгрөг</b>			
31211	Төрийн сангийн харилцах	158,2	233,1	74,9
31213	Арилжааны банк дахь харилцах	0,01	0,4	0,39

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар оны эцэст нийтдээ 233,5 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарчээ. Мөнгөн хөрөнгийн бүтцийг авч үзвэл нийт үлдэгдэл мөнгөний 0,4 сая төгрөг нь арилжааны банкин дахь, 233,1 сая төгрөг нь төрийн сан дахь харилцах дансны үлдэгдэл байна. Үүнд: ОНХСангийн үлдэгдэл 5,9 сая төгрөг, Сум хөгжүүлэх сангийн үлдэгдэл 48,6 сая төгрөг, Орон нутгийн орлогын данс үлдэгдэл 174,8 сая төгрөг, эргэлтийн эмийн сангийн үлдэгдэл 0,4 сая төгрөг, төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 3,7 сая төгрөг байна.

Арилжаны банкинд байгаа 0,4 сая төгрөг нь эргэлтийн эмийн сангийн үлдэгдэл байна.

#### 6.3.2 Авлагын бүртгэл, тайлагнал

Хүснэгт №06 /сая төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>268,2</b>	<b>212,2</b>	<b>-56,0</b>
3351	Ажиллагчидтай холбогдсон авлага	0	0,9	-0,9
3352	Төлбөртэй үйлчилгээний авлага			
	Татаас, санхүүжилтийн авлага	18,3	0	-18,3
	<b>Бусад авлага</b>	<b>0,8</b>	<b>0,6</b>	<b>-0,2</b>
	Байгууллагаас авах авлага	0,2	0,2	0
	Хувь хүмүүсээс авах авлага	0,6	0,4	-0,2
	Зээлийн авлага	249,1	210,6	-38,5
	Хувь хүмүүст олгосон зээл	249,1	210,6	-38,5

Санхүүгийн тайлан дахь авлагын үлдэгдэл өмнөх оноос 56,0 сая төгрөгөөр буурсан дүнтэй байна. Сум хөгжүүлэх сангийн 38,5 сая төгрөгөөр, ОНХСангийн авлага 18,3 сая төгрөгөөр буурсан байна.

### 6.3.3 Бараа материалын бүртгэл, тайлагнал

Хүснэгт №07 /сая төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
35	БАРАА МАТЕРИАЛ	279,1	284,8	5,7
351	Түүхий эд материал	6,4	7,6	1,2
354	Хангамжийн материал	272,7	277,2	4,5

Бараа материалын үлдэгдэл оны эхнээс 5,7 сая төгрөгөөр өссөн байна. Түүхий эд 1,2 сая төгрөгөөр, хангамжийн материал 4,5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Тайлант онд 25,4 сая төгрөгийн материалыг үнэ төлбөргүй хүлээн авчээ.

### 6.3.4 Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

Хүснэгт №08 / сая төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5174,3	4862,7	-311,6
391	Газар			
392	Биет хөрөнгө	5172,6	4861,3	-311,3
393	Биет бус хөрөнгө	1,7	1,4	-0,3

Үндсэн хөрөнгө оны эхнээс 311,6 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд 3,8 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авч, 32,5 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авчээ. Тайлант онд 219,5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, 173,6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг шилжүүлсэн байна.

Тайлант онд үндсэн хөрөнгөнд 285,9 сая төгрөгийн элэгдэл тооцож, 157,5 сая төгрөгийн элэгдлийг хасах бичилт хийж, хуримтлагдсан элэгдлийн үлдэгдэл 2964,9 сая төгрөгт хүрсэн байна.

Төсөвт байгууллагууд 206,1 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авснаас ЗДТГ нь 176,1 сая төгрөгийн, Соёлын төв 0,6 сая төгрөгийн, сургууль нь 29,4 сая төгрөгийн хөрөнгийг хөрөнгө оруулалтаар хүлээн авчээ.

### 6.3.5 Өр төлбөрийн бүртгэл, тайлагнал

Хүснэгт №09 /сая төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт бууралт
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	42,1	37,4	4,7

<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>42,1</b>	<b>37,4</b>	<b>4,7</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	4,4	25,4	21,0
	Ажилчидтай холбогдсон өглөг	4,4	25,4	21,0
	Бараа үйлчилгээний зардлын өглөг			
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	37,6	12,0	25,6
	Байгууллагад төлөх өглөг	37,2	10,4	26,8
	Хувь хүмүүст төлөх өглөг	0,5	1,6	1,1

Оны эхэнд 42,1 сая төгрөгийн өглөгтэй ба оны эцэст 37,4 сая төгрөг болж, үлдэгдэл 4,7 сая төгрөгөөр буурсан байна. Төсөвт байгууллагуудын өглөг 36,6 сая төгрөг, СХСангийн өглөг 0,8 сая төгрөг байна.

### **6.3.6 Цэвэр хөрөнгө/ өмчийн талаар**

Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангаар эзэмшигчийн өмч 282,0 сая төгрөгөөр буурч 5555,8 сая төгрөг болсон байна. Үүнээс ЗГОКапитал 2227,3 сая төгрөг, дахин үнэлгээний нэмэгдэл 1218,3 сая төгрөг, хуримтлагдсан үр дүн 2110,2 сая төгрөг байна.

Тайлант онд -281,9 сая төгрөгийн үр дүнтэй ажиллаж, хуримтлагдсан үр дүн энэ хэмжээгээр буурсан байна.

### **Долоо. Шилэн дансны мэдээлэл**

Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй. Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянав.

### **Найм. Аудитын дүнгийн талаар**

#### **8.1. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:**

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 6 чиглэлд 11 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 40 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв. Үр дагаварыг тодорхойлвол: Аудитаар санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэхээр алдаа зөрчил илрээгүй болно.

#### **8.2. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:**

Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний орон нутгийн орлого, орлогын ерөнхий данс, санхүүжилт орлого, зардал зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

### **8.3. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:**

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв.Аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөх материаллаг алдаа зөрчил илрээгүй боловч анхаарал татах дараах асуудал байна.Үүнд:

1.Өнгөрсөн оны санхүүгийн тайланг е-тайланд аудит хийгдсэн тайлантай тохируулж засаагүйгээс зарим байгууллагын санхүүгийн тайланд эхний үлдэгдэл, орлого, зарлагын дүн зөрүүтэй байна.

Төсөвт байгууллагуудын тайлант оны аудит хийгдсэн санхүүгийн тайланг При баланс болон е-тайлан программ дахь санхүүгийн тайлантай нэгбүрчлэн тулгаж, алдаа зөрүүг арилгаж, Төвлөрүүлэн захирагчийн аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэлээ.

*Шийдвэрлэсэн: Энэхүү алдааг цаашид давтан гаргахгүй байхыг асуудлын бүртгэлд тэмдэглэж анхааруулав.*

### **8.4. Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:**

Байхгүй.

### **8.5. Анхаарал татахуйц бусад чухал асуудал:**

Байхгүй.

### **8.6. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:**

Байхгүй.

### **8.7. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:**

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн асуудлыг алдаа зөрчлийн нэгтгэл маягтаар нэгтгэж харуулав. /ТАБ-СТА-В-4/

### **8.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

**8.9. Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн талаар**

Булган сумын бүрэн дунд сургууль, Шүвтэрийн бага сургууль, Ёлтын бага сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Ёлтын цэцэрлэг, ЭМТ, ТТЗ-ийн СНТайланд бие даасан дүгнэлт гаргаж, ИТХ, Соёлын төвийн санхүүгийн тайланд итгэл үзүүлж, ЗДТГ, ОНХСан, СХСан, БОХСан, ЭЭСангийн санхүүгийн тайланг түүвэрт хамруулж, Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн дүгнэлтэд оруулав.

Хүснэгт №10

Төсвийн шууд захирагчийн нэр	Алдаа, зөрчлийн дүн /сая. төг/	Аудиторын санал дүгнэлт бүгд	Үүнээс			
			Зөрчилгүй санал дүгнэлт	Хязгаарлалттай санал дүгнэлт	Сөрөг санал дүгнэлт	Түүвэрт хамруулсан
ЗДТГ	13,3					1
Бүрэн дунд сургууль		1	1			
Шүвтэрийн бага сургууль						1
Ёлтын бага сургууль						1
Хүүхдийн цэцэрлэг	60,0	1		1		
Ёлтын хүүхдийн цэцэрлэг	7,2	1	1			
ЭМТөв	11,9	1		1		
ТТЗ-ийн СНТайлан	0	1	1			
<b>Дүн</b>	<b>92,4</b>	<b>5</b>	<b>3</b>	<b>2</b>		<b>3</b>

Булган сумын төсөвт байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийтдээ 92,4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, залруулга хийгдсэн байна.

### 8.10. Зөрчилгүй санал дүгнэлт

Булган сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 он оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитлагдсан санхүүгийн тайлан ..... хуудас хавсаргав.

#### АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

М.ХУАНГАН  
ОГНОО:2018.03.28  
Х.ЖЕНИСБЕК  
ОГНОО:2018.03.28

М.АЙНУР ОГНОО:2018.03.28